



**ШИНЭ ИХ ТЭРБУМ
АУДИТ ХХК**

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
1-р хороо, 12-р хороолол, North center, 204 тоот
Утас: 9919-9075, 8804-3708, И-мэйл: Ikhterbum@gmail.com

“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК-ийн
удирдлагад

2025.03.28 № 25/26
танай _____-ны № _____-т

Удирдлагад хүргэх захидал

“Жуулчин дюти фрий” ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайланд аудит хийх явцад бидний анхаарал татсан санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа, дотоод хяналтын системийг сайжруулах тухай асуудлуудыг энэхүү захидалд тусгасан болно.

“Жуулчин дюти фрий” ХК -ийн хэрэгжүүлдэг нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан болно. Санхүүгийн тайланд аудит хийх явцад ажиглагдсан бидний өгсөн зөвлөмжийг анхаарч, хүлээн авч, хэрэгжүүлж ажиллана гэдэгт итгэж байна. Түүнчлэн тайланд бичигдсэн зөвлөмжийн талаар ярилцах, тэдгээрийг хэрэгжүүлэх ажилд туслухад бэлэн байх болно.

Аудитын ажлын явцад бидэнтэй хамтран ажиллаж, туслалцаа үзүүлж байсан “Жуулчин дюти фрий” ХК -ийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад талархлаа илэрхийлье.

Удирдлагад өгөх зөвлөмж

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дор тэмдэглэв.

1. Он дамжин бүртгэгдсэн авлага, өглөгийн тооцооны талаар

Бодит байдал

3 харилцагчаас авах 4,538.1 мянган төгрөгийн авлага, 2 харилцагчийн 787.0 мянган төгрөгийн өглөг он дамжин бүртгэгдсэн. /Хавсралт-1/

Зөвлөмж

Авлага, өглөгийн тооцооны үлдэгдлийг улирал бүр тооцоо нийлж актаар баталгаажуулж байх, хяналт тавих, найдваргүй авлага үүсгэхгүй байх арга хэмжээ авах;

2. Он дамжин бүртгэгдсэн ногдол ашгийн өглөгийн талаар

Бодит байдал

977,156.8 мянган төгрөгийн ногдол ашгийн өглөг он дамжин бүртгэгдсэн байна. /Хавсралт-2/

Хавсралт -1

Он дамжин бүртгэгдсэн авлагын жагсаалт.

	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
УБТЗ ЗҮ Буудал	2,300,000.00	2,300,000.00
Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын газар	1,669,500.00	1,669,500.00
Цайдам трейд ХХК	568,636.53	568,636.53
	4,538,136.53	4,538,136.53

Он дамжин бүртгэгдсэн өглөгийн жагсаалт.

	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Талын Эзэн ХХК	668,583.00	668,583.00
Набэяа Монгол ХХК	118,400.00	118,400.00
	786,983.00	786,983.00

Хавсралт -2

	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Ногдол ашгийн өглөг		
Бусад хувьцаа эзэмшигчид	977,156,755.45	977,156,755.45

Хавсралт -3

Үлдэгдэл өгтөггүй болсон үндсэн хөрөнгийн жагсаалт

№	Үндсэн хөрөнгийн нэр	Хөрөнгийн код	Өртөг	Тоо ширхэг	Нийт үнэ
1	Файлын шүүтээ /өндөр шаргал/	FRN004	643,992	1 ш	643,992
2	Хувцасны шүүтээ /өндөр шаргал/	FRN005	503,384	1 ш	503,384
3	Дэлгүүрийн лангуу /цагаан өнгөтэй лед гэрэлтэй, 12ш ком том, 1ш булан/	FRN020	8,539,268	1 ш	8,539,268
4	Шилэн хаалт 11шир ком	FRN021	4,744,550	28 мкв	4,744,550
Нийт дүн			14,431,194		14,431,194

Хавсралт -4

Тайлан	Цалин зардал	НДШ зардал
НДШ тайлан	286,730,936.74	35,620,959.25
Санхүү тайлан	281,222,978.82	36,793,998.83
Зөрүү	5,507,957.92	(1,173,039.58)

2023 оны Санхүүгийн тайлангийн аудитыг хийсэн манай компаниас өгсөн аудитын зөвлөмжийн хэрэгжилт

Д/д	Аудитын зөвлөмж	Хяналт/ Аудит	Тайлбар
1	<u>1. Авлага, өглөгийн тооцооны үлдэгдлийн талаар.</u> Бодит байдал: 3 харилцагчийн 14,830.0 мянган төгрөгийн авлага, 2 харилцагчийн 787.0 мянган төгрөгийн өглөг он дамжин бүртгэгдсэн. Зөвлөмж: Он дамжин бүртгэгдсэн авлага, өглөгийн үлдэгдлийг шийдвэрлэх;	Хэрэгжүүлээгүй	Тайлант хугацаанд өмнөх оны алдаа зөрчил хэвээр байна.
2	<u>2. Зардлын дансны толилуулгын талаар.</u> Бодит байдал: Санхүү төрийн сан руу илгээсэн санхүүгийн тайлангийн тодруулгаар 457.9 мянган төгрөгийн цалингийн зардлыг илүү, 1,387.0 мянган төгрөгийн засвар үйлчилгээний зардлыг илүү, уг хоёр зардлын нөлөөллөөр бусад зардлыг 1,844.9 мянган төгрөгөөр дутуу тайлагнаж толилуулсан байна. Зөвлөмж: Санхүүгийн тайлангийн тодруулгыг бүртгэлийн дагуу үнэн зөв толилуулж байх;		
3	<u>3. Цалингийн зардал, бүртгэл тооцооны талаар.</u> Бодит байдал: Цалингийн зардал нь НДШ-ийн тайлангаас 3,398.2 мянган төгрөгөөр, НДШ-ийн зардал 815.3 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй илэрхийлэгдсэн. Зөвлөмж: Цалингийн зардал болон нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг холбогдох тайлнуудын дагуу үнэн зөв бүртгэж байх;	Хэрэгжүүлээгүй	Тайлант хугацаанд өмнөх оны алдаа зөрчил хэвээр байна.
4	<u>4. Хувь нийлүүлсэн хөрөнгийн үлдэгдлийн талаар.</u> Бодит байдал: Хувийн өмчийн дүнг компаний дүрэмтэй тулган шалгах 6,536.2 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Зөвлөмж: Компанийн тухай хуулийн дагуу компанийн дүрмийг шинэчилж, бүртгэх байгууллагаар баталгаажуулах;	Хэрэгжүүлээгүй	Тайлант хугацаанд өмнөх оны алдаа зөрчил хэвээр байна.

Зөвлөмж

Он дамжсан өглөгийн үлдэгдлийг хувыцаа эзэмшигчдийн хуралд хэлэлцүүлэн шийдвэр гаргуулах.

3. Үндсэн хөрөнгийн бүртгэлийн талаар

Бодит байдал

14,431.2 мянган төгрөгийн тавилга эд хогшил элэгдлээрээ анхны өртөгөө нөхөж үлдэгдэл өртөггүй болсон байна. /Хавсралт-3/

Зөвлөмж

НББОУС-16. Үндсэн хөрөнгийн 34. "Дахин үнэлгээ хийх давтамж нь уг дахин үнэлж буй үндсэн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс хамаардаг. Үнэ цэнэд нь ялимгүй бага өөрчлөлт ордог үндсэн хөрөнгийн зүйлсийн хувьд гурав буюу таван жил тутам дахин үнэлэх шаардлагатай байж болно" гэсэн заалтыг мөрдөх

4. Цалингийн зардал, бүртгэл тооцооны талаар

Бодит байдал

Цалингийн зардал нь НДШ-ийн тайланд 5,508.0 мянган төгрөгөөр, НДШ-ийн зардал 1,173.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгагдсан. /Хавсралт-4/

Зөвлөмж

- Цалингийн зардлыг нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татвар суутгаагүй нийт дүнгээр бүртгэл тайланд тусгаж байх;
- Нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд зөвхөн ажил олгогчоос төлөх зардлыг оруулж бүртгэх, ажилтнуудаас суутгах нийгмийн даатгалын шимтгэлийг цалингийн өглөгөөс бууруулж бүртгэж байх;

5. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаар

Бодит байдал

Компанийн 2023 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайлангийн аудитын ажлын үр дүнгээр 4 заалт бүхий зөвлөмжийг компанийн удирдлагад хүргүүлсэн байна. Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. /Хавсралт -5/

Дээрх заалтын дагуу зөвлөмжийн биелэлтийн хариуг бидэнд доорх хаягаар, албан бичгээр ирүүлнэ үү. Зөвлөмжүүдийг хэрэгжүүлж ажиллана гэдэгт найдаж байна. Та бүхний ажилд амжилт хүсье.

